

НЭЭЛТТЭЙ НИЙГМИЙН ТУХАЙ К.ПОППЕРЫН ҮЗЛИЙГ ШИНЖИЛСЭН НЬ

Ш.Ганхуяг (Ph.D)

Ж.Бямбасүрэн (магистр)

ШУА-ийн Философийн хүрээлэн

Түлхүүр үг: историцизм, историзм, хаалттай нийгэм, нээлттэй нийгэм, ардчилсан нийгэм

Товч утга: Нээлттэй нийгмийн тухай К.Попперийн үзлийг шинжлэхэд А.Бергсоны “хаалттай нийгэм” гэсэн ойлголтыг судлах шаардлагатай болдог юм. Учир нь хаалттай нийгмийн онцлог шинжийг ойлгосноор нээлттэй нийгмийн давуу тал, онцлогийг мэдэх бололцоотой. К.Поппер “нээлттэй нийгэм”-ийн гол шинжийг тодорхойлохдоо “ийм нийгэм бол иргэдийнхээ бие даасан, бүтээлч, шүүмжлэлт үйл ажиллагааны үр дүн байдаг” гэжээ. Тиймээс нийгмийн хөгжил нь тусгай объектив хууль, зүй тогтлоор тодорхойлогдохгүй хэмээн К.Поппер үзсэн юм. Ингэж нээлттэй нийгмийн шинжийг тодруулахдаа тэрээр историзм, историцизм хэмээх хоёр ойлголтын зөрүүг тайлбарласан байдаг. Өгүүлбээс “историзм бол юмыг түүхэн ёсоор үзэхийг, өөрөөр хэлбэл түүхчлэн үзэхийг шаарддаг, энэ чанараараа шинжлэх ухааны хувьд зөв зүйтэй. Харин историцизм бол өөр юм. Историцизм нь нийгмийн ухаан болбоос ирээдүйг урьдчилан харах зорилгоор түүхийн хуулиудыг нээх ёстой гэж үздэг. Историцизмын ёсоор урт удаан хугацааны урьдчилан харахуйг гаргавал энэ нь шалгалт, няцаалтад өртөхгүй, иймд үл гүйцэлдэх, зөгнөн мөрөөдсөн шинжтэй болно. Ийм зөгнөл мөрөөдөл шинжлэх ухааны урьдчилан харахуйтай огт тохирохгүй ажээ. Ийнхүү нээлттэй нийгмийн тухай үзлээ тэрээр “Нээлттэй нийгэм, түүний дайснууд”, “Түүхчлэх үзлийн гуйланчлал”, “Диалектик гэж юу вэ?”, “Марксын зөгнөл, Марксын ёс зүй” гэх мэт олон зохиол бүтээлүүддээ тодоор илэрхийлсэн байдаг.

Философийн түүхэнд “хаалттай нийгэм” гэдэг нэр томъёог анх хэрэглэсэн эрдэмтэн бол А.Бергсон билээ. Тэрээр нийгмийг амьтанчлах арга зүйн үүднээс тайлбарласан байдаг. Ингэж тайлбарлахдаа үүр бутуар амьдардаг зохион байгуулалт бүхий зөгий, шоргоолж, хүн төрөлхтний хамтлаг зэргийг нийтэд нь “нийгэм” хэмээсэн байдаг.¹ Тэрээр: “нийгэм бол хаалттай ба нээлттэй хоёр хэв маягт хуваагддаг гээд, тэдгээр хэв маяг тус бүрт шашин, ёс суртахуун хоёрын статик ба динамик гэсэн хоёр өөр хэв маяг тохирдог” тухай өгүүлсэн байдаг.

“Хаалттай нийгэм нь хаалттай ёс суртахуун, статик шашинд үндэслэдэг бол нээлттэй нийгэм нь динамик шашин, нээлттэй ёс суртахуунд суурилдаг” хэмээн А.Бергсон тодорхойлжээ.

А.Бергсоны тайлбарласнаар хаалттай ёс суртахуун гэдэг бол нэг үгээр “дарамт” юм. Учир нь, ийм хаалттай нийгэмд хүн өөрийгөө амьд биеийн өчүүхэн

¹ Анри Бергсон. Два источника морали и религии. М., 1994, с.114-д энэ тухай үзнэ үү.

жигиг эд эс гэж хүлээн авч, бусдын хүсэл сонирхолыг өөрийнхөөсөө дээгүүр тавьж нэг ёсондоо хэсэг нь бүхэлдээ захирагдах чанд сахилга бат бүхий, үүргээ албадлагын механизм дор биелүүлдэг ийм хаалттай нийгмийн иргэн бол хатуухан хэлэхэд робот юм. Харин нээлттэй нийгэмд динамик шашин, динамик ёс суртахуун үйлчлэх бөгөөд энэхүү динамик хэмээх ойлголтыг хүсэл эрмэлзэл, сонголт, эрх чөлөө гэсэн утгаар илэрхийлж байна.

Харин К.Попперийн боловсруулсан нээлттэй нийгмийн тухай үзэл нь А.Бергсоноос эхтэй. Тэрээр хаалттай нийгмийг эсэргүүцэн нийгэмд объектив хууль, зүй тогтол байхыг хурцаар шүүмжилж, энэ үзлийнхээ хөрсөн дээрээс нээлттэй нийгмийн тухай өөрийн үзэл баримтлалаа боловсруулсан байдаг. Энэ тухай санаагаа “Нээлттэй нийгэм, түүний дайснууд”, “Түүхчлэх үзлийн гуйланчлал”, “Диалектик гэж юу вэ?”, “Марксын зөгнөл, Марксын ёс зүй” гэх мэт олон зохиол бүтээлүүддээ илэрхийлжээ. Түүнчлэн хаалттай болон нээлттэй нийгмийн тухай К.Попперын үзэл санаа Бергсоноос үүсэлтэй хэдий ч А.Бергсоны үзэлд Л.Леви-Брюль, Б.Малиновский, Э.Тайлор, Д.Фредер зэрэг нэрт угсаатан судлаач, соёлын түүхчдийн судалгаа чухал нөлөө үзүүлсэн байдаг.

Марксизмын онолыг удирдлага болгож, ХХ зуунд Европ, Ази, Латин Америк зэрэг газар нутаг дахь нэлээд орнууд социализм, коммунизмыг байгуулах үйл хэргийг бүтээсэн нь тэр үеийн дэлхий дахины хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж, ХХ зууны 60-70-аад онд Ази, Африкийн олон орон колончлолоос ангижирч социалист чиг баримжааг гол зорилтоо болгосон байдаг. Гэвч энэ бүхэн нь нийгмийн шалгуурыг даалгүйгээр ХХ зууны 90-ээд оноос задран унасан юм.

Марксизмд нийгмийн философийг түүхэн материализмын хүрээнд номлож нийгмийн аливаа үзэгдэл, үйл явцыг хүн, нийгмийн ухамсраас ангид нийгмийн ахуйгаас ургуулан тайлбарлах нь түүхэн материализмын гол зарчим нь байжээ. Тэгэхдээ нийгмийн ахуй анхдагч, нийгмийн ухамсар хоёрдогч гэж үздэг. Нийгмийн ахуйгаас нийгмийн үйлдвэрлэлийн аргын асуудлыг дэвшүүлэн, нийгмийн хөгжил бол нийгмийн үйлдвэрлэлийн аргын солигдол юм гэж тайлбарладаг. Эндээс хүй нэгдэл, боол эзэмшил, феодализм, капитализм, коммунизм гэсэн зайлшгүй туулах нийгэм эдийн засгийн хөгжлийн таван үе шат, таван формацийн онолыг боловсруулжээ.²

Формацийн онолын мөн чанар бол нийгмийн амьдралын янз бүрийн салбарын дотроос эдийн засгийн салбарыг гол болгон ялгаж, нийгмийн харилцааны бүхий л цогцолбор дотроос үйлдвэрлэлийн харилцааг нийгмийн хөгжлийн эцсийн шат гэж үздэг байв. Энэ үүднээсээ нийгэм эдийн засгийн таван формацийг даван туулснаар нийгэм хөгжин дэвшинэ хэмээн тайлбарладаг байжээ.

Харин “К.Поппер шинжлэх ухааны философийн арга зүйн зарчмаар түүхийн материализмыг шүүмжилж, нийгмийн хөгжлийн объектив хууль зүй тогтлыг няцаасан юм. Тэгээд ч ямар нэгэн сургаалыг баримталж түүх хөгжинэ гэвэл түүн шиг хуурамч үзэгдэл байхгүй, иймээс төрийн тухай Платоны сургаал ч, марксист түүхэн материализм ч нийгмийн хөгжлийн удирдамж болж чадахгүй юм. Хүн, нийгмийн аливаа үйл ажиллагаа нь урьдчилан тогтоож заасан чиг хандлагаар явагдахгүй, харин бодит байдлыг шүүмжлэн няцааж хувирган өөрчлөх үйл явц л түүхийг урагш хөгжүүлдэг гэж К.Поппер үзжээ”³

² Ш.Ганхуяг. *Нийгмийн философийн түүхэн тойм. Эрдэм шинжилгээний бичиг. №8/174/*. УБ., 2001, 25 дахь тал

³ Ш.Ганхуяг. *Түүхчлэх үзлийн талаар эргэцүүлэхэд. МУИС. НШУС. Философи шашин судлал*

Ингээд К.Поппер историзм, историцизмын ялгааг тайлбарласан байдаг. Тодруулбал, “историзм бол юмыг түүхэн ёсоор үзэхийг, өөрөөр хэлбэл түүхчлэн үзэхийг шаарддаг, энэ чанараараа шинжлэх ухааны хувьд зөв зүйтэй. Түүхийн явцад нотлогдсон, шинжлэх ухаан хүлээж авсан тийм урьдчилан харахуй (ж.нь: нар хиртэх) шүүмжлэл, шалгалт тодруулга, нэмэлтэд нээлттэй байдаг. Харин историцизм бол өөр. Историцизм нь нийгмийн ухаан болбоос ирээдүйг урьдчилан харах зорилгоор түүхийн хуулиудыг нээх ёстой гэж үздэг. Историцизмын ёсоор урт удаан хугацааны урьдчилан харахуйг гаргавал энэ нь шалгалт, няцаалтад өртөхгүй, иймд үл гүйцэлдэх, зөгнөн мөрөөдсөн шинжтэй. Ийм зөгнөл мөрөөдөл шинжлэх ухааны урьдчилан харахуйтай огт тохирохгүй гээд дараах үндэслэлийг дэвшүүлсэн байдаг. Үүнд:

1. Шинжлэх ухааны түүх гэнэтийн гайхалтай явдлаар дүүрэн байдаг, ийм явдлууд нь төлөгчлөх боломжийг өөрийг нь айхавтар хязгаарладаг;
2. Нийгмийн хөгжлийн тогтвортой хууль оршин байдаг гээд урьдчилаад бодчихсон нь хууль, хандлага гэсэн ойлголтуудыг хольж бантагнуулсан арга зүйн алдаанд үндэслэжээ;
3. Бид л түүхэнд ийм, тийм утга учир бий гэж хэлээд байдаг болохоос биш түүхэнд ямар ч утга учир байдаггүй;
4. Түүх цагаатгадаггүй, харин шүүдэг” гэжээ.⁴

К.Попперийн философи дахь историзм, историцизм хоёр бол арга зүйн эерэг, сөрөг хоёр зарчим болох тухай санааг доктор Б.Даш-Ёндон авч үзэхдээ, энэ хоёр нэр томъёог орчуулаагүй нь тохиолдлын биш болов уу. Учир нь манайд энэ хоёр нэршлийг хоёуланг нь түүхчлэх үзэл гэж орчуулсан тохиолдол цөөнгүй байдаг нь уншигчдыг төөрөгдүүлдэг. Манай зарим зохиогч “историцизм” гэдгийг “түүх бүтээх үзэл”, “историзм” гэдгийг “түүхчлэх үзэл” гэж орчуулсан байдаг. Ингэж орчуулсан тохиолдолд үүнийг баримтлахад болохгүй гэх газаргүй санагдана хэмээн доктор Б.Даш-Ёндон нэгэн өгүүлэлдээ бичжээ.

К.Попперийн өгүүлсэн дээрх санаа нь К.Марксын формацийн онолыг зохиомол зөгнөл гэж илэрхийлээд үүнийхээ шалтгааныг заахдаа: “...ирээдүй урьдаас тогтоогдсон л байдаг юм бол, өөрөөр хэлбэл, ирээдүй өнгөрсний дотор байгаа, түүнд ороолттой байгаа юм бол, шинжлэх ухаан ирээдүйг зөгнөн хэлж чадна гэх үнэмшмээр үндэслэгээг Маркс ашигласнаас болж, шинжлэх ухааны нарийн чанд аргачлал нарийн чанд учир шалтгааны холбоо (детерминизм)-н дээр суурилах ёстой гэсэн хуурмаг итгэл үнэмшилтэй болоход хүрчээ”⁵ гэсэн байдаг. Ерөөс болоод өнгөрсөн явдлыг дараа нь олон талын өнцгөөс ийм тийм утга учир бүхий гэж тайлбарлаж болох ч тэдгээр тайлбар болон болоогүй зүйлийг болох юм шиг урьдчилан тогтоох нь хэтэрхий гэнэн бөгөөд үнэмшилгүй зүйл болох юм.

Орчин үеийн онолын ном зохиолуудад “нээлттэй нийгэм” гэсэн нэр томъёо тэр бүр хэрэглэгдээд байдаггүй. Үүний шалтгаан нь “нээлттэй нийгэм”, “ардчилсан нийгэм” гэдэг хоёр нэр томъёог үндсэндээ төсөөтэй утгаар хэрэглэж байгаатай холбоотой болов уу. Ийм бодлоо дараах зарим үндэслэлээр тодруулбал:

эрдэм шинжилгээний бичиг. №271/37. VI. УБ., 2007, 87 дахь тал

⁴ Б.Даш-Ёндон. Карл Поппер.-Монгол улсын шинжлэх ухааны академи. Философи, социологи, эрхийн хүрээлэн. Философи, эрхийн судлал. XXIII боть. УБ., 2008, 71-72 дахь тал

⁵ Карл Р.Поппер. Нээлттэй нийгэм, түүний дайснууд. II боть. УБ., 2009, 94-95 дахь тал

- Нээлттэй нийгэм бол иргэд нь тайван амьдардаг, эрх чөлөөг өндрөөр үнэлдэг, хариуцлагатай, энэ хариуцлагыг баяр баясгалантай хүлээн авч биелүүлдэг ардчилсан нийгэм бөгөөд ийм нийгэмд энх тайван, эрх чөлөө, найрамдлыг өндөр үнэлж, тэдгээрийг бодитой хэрэгжүүлэх боломж бүрдсэн байдаг.
- Нээлттэй нийгэм бол нийгмийн амьдралын бүх хүрээнд монополийг үгүйсгэж, олон ургальч үзлийг хэрэгжүүлдэг нийгэм юм. Чөлөөт зах зээл бол нээлттэй нийгэмд зайлшгүй байх бүрэлдэхүүн хэсэг мөн. Зах зээлийн эдийн засаг хөгжиж, хуулийг дээдлэн хүндэтгэдэг, ардчилсан замаар сонгогдсон засгийн газартай, иргэдийг нийгмийн амьдралд оролцох бололцоог бүрэн хангасан, цөөнхийн санаа бодлыг хүндэтгэсэн байдаг зэрэг нь нээлттэй нийгмийн ерөнхий хэв шинжийг тодорхойлно. Нээлттэй нийгмийн гол үзэл санаа нь хуулийн засаглалын үзэл санаа юм. Зах зээлийн харилцаанд үндэслэсэн, чөлөөт сонголт хийх өргөн боломж олгодог нийгмийн эрх зүйн системгүйгээр сэтгэхийн аргагүй юм.

Энэ мэтээр А.Бергсон, К.Поппер нарын үзлийг өөрсдийнх нь бүтээлдээ илэрхийлсэн нээлттэй нийгэм бол ардчилсан нийгмийг тухайлдаг гэж үндэслэсэн тэдгээрийн санааг лавшруулан бататгаж, тайлбарлаж болох юм. Гэхдээ “нээлттэй нийгэм” гэдэг ойлголтыг К.Поппер “ардчилсан нийгэм” гэдэг ойлголтоос тодорхой, явцуу утгаар авч үзсэн байх тал бас анзаарагддаг. Тухайлбал нээлттэй нийгмийн шинжүүдийг тэрээр тоочсон байгаа нь ардчилсан нийгмийн бүх биш, харин зарим шинж агуулагдаж байдгийг анхаарах нь зүйтэй.

К.Поппер нээлттэй нийгмийн шинжүүдийг илрүүлэн тайлбарлахдаа хаалттай нийгмийн зарим шинжтэй харьцуулан авч үзжээ. Түүний тайлбараар хүний амьдралд төр засгаас тогтоосон хууль тогтоомжоос гадна хувь хүн, гэр бүл, байгууллагын дотор дагаж мөрдөх ёстой дүрэм журмууд гэж байна. Жишээлбэл, идэж уух, босох суухтай холбоотой хорио цээр, бусадтай эвтэй, найрсаг харилцах ёстой гэх мэт өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэх ёстой цээр гэж бий. Ийм хорио цээр, дүрмүүд нь хаалттай нийгэмд аяндаа бий болдог хэм хэмжээнүүд юм.

Ер нь эрт үеийн овгийн зохион байгуулалттай үед ёс суртахуун, хэв журмын тал дээр ямар нэгэн зөрчил маргаан бараг гардаггүй байж. Учир нь тэдгээр хүмүүс хэв журмыг ёсчлон биелүүлж үүргээ аяндаа ухамсарлан гүйцэтгэдэг байсан учраас үл ойлголцол харьцангуй бага гардаг бололтой юм. Харин орчин үед энэ байдал өөрчлөгдөж төр засгаас тогтоосон хууль тогтоомжоос гадна бидний заавал мөрдөх ёстой хувийн хариуцлага болж иржээ. Энэ нь өөрсдөө бие даан шийдвэрлэх асуудлууд бий болсон нь хувь хүний шийдвэр ямар нэг нийтийн дүрэм журмыг өөрчлөх чадвартай болж байгаагийн тодорхой илрэл юм. Ингэж үзэл бодол, санал шүүмжээ чөлөөтэй илэрхийлэх боломжтой болж байгаа нь нээлттэй нийгэм үүсэх сэтгэл зүйн ба ёс суртахууны тодорхой үндэс болдог ажээ.

Нээлттэй нийгэм бол иргэдийнхээ бие даасан, бүтээлч, шүүмжлэлт үйл ажиллагааны үр дүн болж байдаг. К.Попперийн үзэж буйгаар “нийгмийн зохион байгуулалт нь няцаагдан шүүгдэх боломжгүй бол хаалттай нийгэм болж, зогсонги байдалд орно, харин няцаалт шүүлтэд байнга өртөж өөрөө өөрийгөө цэвэрлэж чадаж байгаа нийгэм нь нээлттэй нийгэм болж хөгжин дэвших бололцоог олно гэж тэрээр тодорхойлжээ.”⁶

⁶ Ш.Ганхуяг. Түүхчлэх үзлийн талаар эргэцүүлэхэд. МУИС.НШУС. Философи шашин судлал. Эрдэм шинжилгээний бичиг. №271/37/VI. УБ., 2007. 87 дахь тал.

Тийнхүү нээлттэй нийгмийн тухай К.Попперийн философи онол бол өөрийнх нь боловсруулсан фальсификацийн зарчмыг арга зүйн үндсээ болгодог. Энэхүү арга зүйн зарчмаа нэн түрүүнд шинжлэх ухааны мэдлэг өсөх нөхцлийнх нь хувьд К.Поппер боловсруулжээ. Тодруулбал, фальсификацийн зарчмын үүднээс аливаа онол нь сайшаан дэмжигдэхээсээ илүү няцаагдан шүүгдэх боломжтой бол тэр онол шинжлэх ухааны мэдлэг болох бололцоотой гэж К.Поппер үзсэн юм.

Гэхдээ фальсификацийн зарчмыг зөвхөн онол, мэдлэгт биш, бас нийгмийн практикт арга зүйн чухал ач холбогдолтой байдаг гэж үзэх бололцоог нээлттэй нийгмийн тухай К.Попперийн онол гэрчилдэг. Уг зарчмыг ийм өргөн арга зүйн зарчим гэж үзэх бололцоог нээлттэй нийгмийн шинжүүдийн тухай дээр дурдсан цөөн мэдээ ч нотолно гэж үзэж байна.

К.Попперийн үзлээр, нээлттэй нийгэмд хүрэх нь бодитой, тэгэхдээ энэ нь бас ямар нэгэн чин хүслэн юм. Ардчилал нь боловсорсон, хөгжсөн, нээлттэй болсон гэх утгаараа нийгэм бүрт адилгүй байж болно. Энэ нь түүх, уламжлал, улс төрийн институт, хүмүүжүүлдэг арга, улмаар хүмүүсээс хамаарна. Одоо байгаагаас илүү ухаалаг нийгэм байж болно, иймд түүн рүү эрмэлзэх ёстой. Энэ эрмэлзэл бодит байдалд биелж болно, энэ бол үл гүйцэлдэх үзэл огт биш шүү! гэж “Нээлттэй нийгэм, түүний дайснууд” зохиолдоо бичжээ. Тэрээр энэ бүх санаагаа үргэлжлүүлж, эхлээд эрх чөлөө, тэгж байж шударга ёс байх учиртай. Эрх чөлөөт нийгэмд бол хайр найргүй шүүмжлэл агаад нягт сайн бодсон шинэчлэлийн аргаар л шударга ёсонд хүрч болно гэж К.Поппер үзсэн юм.

Ингэхлээр орчин үеийн нийгмийн хөгжлийн үндсэн нөхцөл нь шинэ мэдлэг, түүний үрээр үүсдэг бүтээлч шүүмжлэл, шүүмжлэлийн дагуу хийгдэх шинэчлэл, уг шинэчлэлийн өөрийн нь тасралтгүй төгөлдөржил болох учиртай.

Дээрх бүгдийг дүгнэн үзвээс:

- Нийгэм – улс төрийн философи нь байгаль, нийгэм, хүний харьцаан дээр суурилан хөгжих явцад “хаалттай нийгэм” ба “нээлттэй нийгэм” хэмээх ойлголтууд бий болжээ.
- “Нээлттэй нийгэм” гэдэг А.Бергсон, К.Поппер нарын философи баримтлалд зарим нийтлэг тал байна. Үүнд: 1) “Нээлттэй нийгэм” гэж юу болохыг тайлбарлахдаа “хаалттай нийгэм” гэдэг ойлголт бий болгон, тэдгээрийг харьцуулан авч үзсэн байна. 2) Тэдний хувьд “хаалттай нийгэм” бол хүн төрөлхтний түүхийн бүх үе дэх тоталитари нийгмүүд мөн. 3) Мөн тэдний хэн хэнийх нь хувьд “нээлттэй нийгэм” бол ардчилсан шинж бүхий нийгэм юм. Үүний зэрэгцээ “нээлттэй нийгэм”-ийн тухай А.Бергсон, К.Поппер нарын хувьд арга зүйн тодорхой ялгаа байдаг. Үүнд: А.Бергсоны баримталсан гол философи арга зүй нь амьтанчлах үзэл (биологизм), бүр тодорхой хэлбэл биологийн эволюционизм мөн. Харин К.Попперийн баримталсан философийн гол арга зүй нь түүний өөрийнх нь боловсруулсан фальсификацийн зарчим, бүр тодорхой хэлбэл оршин буй нийгмийн объектив бодит байдал, онолын мэдлэг (ялангуяа шинжлэх ухаан) аль алинд шүүмжлэлтэй хандаж, алдааг нь илрүүлдэг арга зүй мөн.
- Историцизмыг арга зүйгээ болгодог орчин үеийн сургаалуудын нэг нь марксизм юм. Марксизм бол ХХ зуунд Европ, Ази, Датин Америк дахь олон оронд хэрэгжсэн коммунист дэглэм бүхий нийгмийн онол, үзэл суртлын үндэс

болж иржээ. Энэ нийгэм бол марксист-ленинист ганц үзэл суртал, улсын ба хоршооллын гэсэн хоёр хэлбэртэй зөвхөн нийгмийн өмч, “пролетарийн диктатур” гэдэг утга бүхий бүх шатны дарга нарын ноёрхлын төр зэргийг улс орныхоо хүн амд тулгадаг тоталитари (дарангуй) нийгэм, товчоор хэлбэл хаалттай нийгэм мөн.

Эцэст нь, нээлттэй нийгэм бол шударга ёсонд суурилсан эрх зүйт төрийн шинжүүдийг өөртөө шингээсэн, иргэний нийгмийн үндсэн шинжүүд зохих хэмжээнд төлөвшсөн, хувь хүний эрх, эрх чөлөөг дээдэлдэг, эрх мэдэлтнүүдийн үйл ажиллагаа ард түмний өмнө ил тод байдаг нийгэм мөн. Тийм учраас К.Попперийн боловсруулсан нээлттэй нийгмийн тухай онол бол ер нь ардчилсан нийгмийн тухай онол мөн гэж өмнө нь дүгнэн өгүүлснээ энд давтан дурдъя.

Ном зүй

1. Анри Бергсон. Два источника морали и религии. М., 1994
2. Ш.Ганхуяг. Нийгмийн философийн түүхэн тойм. Эрдэм шинжилгээний бичиг. №8/174/. УБ., 2001
3. Ш.Ганхуяг. Түүхчлэх үзлийн талаар эргэцүүлэхэд. МУИС.НШУС. Философи шашин судлал. Эрдэм шинжилгээний бичиг. №271/37/ VI/. УБ., 2007.
4. Б.Даш-Ёндон. Карл Поппер. ШУА-ийн ФСЭХ. Философи эрхийн судлал. XXIII боть. УБ., 2008
5. Карл Р.Поппер. Нээлттэй нийгэм, түүний дайснууд. I боть. УБ., 2006
6. Карл Р.Поппер. Нээлттэй нийгэм, түүний дайснууд. II боть. УБ., 2009
7. И.Лхам. Нээлттэй нийгмийн босгон дээрх монгол. МУИС. НУФ. Эрдэм шинжилгээний бичиг. №5/142/. УБ., 1999
8. В.А.Смирнов. К.Попперийн зөв: Диалектик логик байх бололцоогүй. Эрх чөлөө ба философи. №4, УБ., 1999

ABSTRACT

It is French philosopher Henri Bergson who first brought into the scientific usage such terms as open society in the history of philosophy. Then Karl Popper analyzing H.Bergson`s and other philosophers account on that conception, wrote the “Open society and it`s enemy”. In the book he presented his own view on the open society. According to Popper the main enemies of the society are communism and fascism. They are most tyrannical forms of rule that deny human right and freedom. A student of Popper, J.Soros inherited his conception and utilized the idea in the reality.